



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/311

Хэрлэн сум

Сургалтад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн байгууллагын мэдээлэл технологийн ажилтнуудад “Технологи аюулгүй байдал кибер мэдээлэл хөдөлмөр” сургалт зохион байгуулахад 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Иргэд олон нийтийг кибер аюулгүй байдлын талаар мэдээ мэдээллээр хангаж, мэдлэгийг дээшлүүлнэ” зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



05
11/13/21
Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 26-ний өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчид нарт “Кибер аюулгүй байдлын чиглэл”-ээр сургалт явуулсан сургагч багшийн төлбөр	-	2 500 000	2 500 000
2	“Технологи, Аюулгүй байдал, Хиймэл оюун ухаан” сэдвүүдээр сургалт явуулсан сургагч багшийн төлбөр	-	2 500 000	2 500 000
Бүгд				5 000 000